



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2021/01/-СТА-ТЕЗ

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Ж.Баяртуул
Утас: 7058-4207, Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Дүрслэлийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна	5
---	---

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.	7
---	---

БҮЛЭГ 3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИН.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.3 хувьтай байна.	12
--	----

ДҮГНЭЛТ:	15
----------------	----

Холбогдох байгууллагын санал:	15
-------------------------------------	----

ҮАГ-т хүргүүлсэн санал:	16
-------------------------------	----

ЗӨВЛӨМЖ:	16
----------------	----

АЛБАН ШААРДЛАГА	17
-----------------------	----

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ	18
----------------------------------	----



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
СС	Сангийн сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2017-2019 оны орлогын гүйцэтгэл, 2020 оны төсвийн орлогын төлөвлөлтийн харьцуулалт.	5
Дүрслэл 2	2020 оны нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.	5
Дүрслэл 3	2017-2019 оны зардлын гүйцэтгэл, 2020 оны төсвийн зардлын төлөвлөлтийн харьцуулалт.	8
Хүснэгт 1	Зардлын төлөвлөлтийг гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа.	9
Дүрслэл 4	Зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь ангилан харуулбал	10
Дүрслэл 5	Зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа.	10
Хүснэгт 2	Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа.	11
Дүрслэл 6	Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг харуулбал.	11
Хүснэгт 3	Хандивын орлогын судалгаа.	12
Хүснэгт 4	Хандивын зарцуулалтын судалгаа.	12
Хүснэгт 5	Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.	14



	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд хийв.
Аудитын зорилт	Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • 2020 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл • 2020 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл • ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшин
Аудитын хамарсан хүрээ	Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд: • Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, • Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; • Нэмэлт төсвийн гүйцэтгэл, • Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн,
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, Гүйцэтгэлийн аудитын арга зүй, журмыг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд аймгийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн ахлах мэргэжилтэнтэй ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Ж.Баяртуул нар хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын 2 дугаар газар болон аймгийн Засаг даргад 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлээ.

1.ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар жилийн төсвийн хязгаар нь орлогын доод, зарлагын дээд хэмжээ бөгөөд Сангийн яам 2020 оны төсвийн жилийн суурь орлогыг 18.6 тэрбум төгрөгөөр хянасныг, төсвийн жилд 22.5 тэрбум болгон 3.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж аймгийн ИТХ-ын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны 04 дүгээр тогтоолоор татварын орлогыг 2,005.7 сая төгрөгөөр бууруулан, татварын бус орлогыг 291.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан байна.


Төсвийн ерөнхийлөн захирагч нь орлогын төлөвлөлтийг өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг бөгөөд 2020 оны нийт орлогыг 25,092.3 сая төгрөгөөр буюу өмнөх оны гүйцэтгэлээс 1.2 хувиар нэмж төлөвлөсөн байна.

Дүрслэл: 1.

/сая төгрөгөөр/



Аймгийн 2020 оны төсвийн нийт орлого 27,802.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөгөөнөөс 10.8 хувь буюу 2,710.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Дүрслэл:2.

Орлогын нийт төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна.

1.Татварын орлогын талаар:

Орлогуудыг нэр төрөл бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

- **Хувь хүний орлогын албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 346.9 сая төгрөг буюу 2.7 хувиар бууруулан төсөвлөсөн байна. Гүйцэтгэл нь 1,495.5 сая төгрөг буюу 12 хувиар өссөн нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татварын урд оны өрийн үлдэгдлийг барагдуулсан, иргэдийн хадгаламж өссөнөөс хадгаламжийн хүүгээс авах татварын орлого нэмэгдсэн, уул уурхайн компаниудад орон нутгийн иргэд бараа ажил үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой ХХОАТ-ын орлого нэмэгдсэн байна.
- **Авто тээврийн хэрэгслийн албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөсөн нь 72.7 сая төгрөг буюу 19.6 хувиар давж биелсэн байна. Тайлант онд авто тээвэр эзэмшигч иргэдийн Ebarimt -д тээврийн хэрэгслийн өрийн мэдээллийг оруулж татварт хамруулах ажлыг зохион байгуулсан, мөн АТҮТ-ийн Дорнод салбартай хамтран авто тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулах тохиолдолд татварын албаны тодорхойлолтыг үндэслэн хассан нь нөлөөлсөн байна.
- **Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг** 3,884.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 101.9 сая төгрөг буюу 2,7 хувиар өссөн байна. Усны нөөц ашигласны төлбөрийн 3,500.0 сая төгрөгийн орлогыг газрын тосны 19, 21-р талбайд үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин тамсаг ХХК-иас, 384.7 сая төгрөгийг бусад аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 6.5 хувиар давж биелсэн нь Петрочайна Дачин тамсаг ХХК 3,589.0 сая төгрөг, бусад аж ахуйн нэгжийн төвлөрүүлэх орлогоо ус ашиглах гэрээний дагуу бүрэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- **Газрын дуудлага худалдааны орлого нь** өмнөх оны гүйцэтгэлийн түвшнийг үндэслэн төлөвлөх боломжгүй орлого бөгөөд тайлант онд дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөсөн газрын байршил болон оролцогчийн тоо хэмжээ гэх мэт тооцоолох боломжгүй олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тус орлогыг тайлант оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан 50.9 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 46.0 сая төгрөгөөр илүү байна. Гүйцэтгэлээр 56.1 сая төгрөг буюу 10.2 хувиар давж биелсэн байна.
- **Газрын төлбөрийг** 555.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 28.8 сая төгрөг буюу 6.0 хувиар өссөн байна. Гүйцэтгэлээр 143.2 сая төгрөг буюу 7.9 хувиар давж биелсэн нь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үүсгэсэн нэхэмжлэхийн дагуу Татварын хэлтэс газрын төлбөрийг барагдуулах ажлыг хамтран зохион байгуулж ажилласан байна.
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг** өмнөх оноос 37.8 сая төгрөг буюу 6.2 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн төлөвлөгөөнөөс 32.4 сая төгрөг буюу 5 хувиар тасарсан нь үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн орлого буурснаас татвараа бүрэн төлөөгүйтэй холбоотой байна.
- **Галт зэвсгийн албан татварын орлого нь** 12.4 сая төгрөг буюу 29.9 хувиар тасарсан байна. Энэ төрлийн орлогын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн байдлаар байнга тасарч байгаа нь Татварын хэлтэс дэх татвар ногдуулсан галт зэвсгийн тоо нь Цагдаагийн газарт бүртгэлтэй галт зэвсгийн тооноос зөрүүтэй байгаагаас шалтгаалсан байна. Үүнд Цагдаагийн газар дахь галт зэвсгийн бүртгэлд жил бүр өөрчлөлт хийгддэггүй бөгөөд үрэгдүүлсэн галт зэвсгийг бүртгэлээс хасуулахад хүндрэлтэй байдаг нь нөлөөлсөн байна.
- Аймгийн хэмжээнд Хэрлэн сум нь **улсын тэмдэгтийн хураамжийг** орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд Төрийн аудитын байгууллагаас 2019 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитуудаар уг асуудлын талаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул ҮАГ-т дахин уламжилж МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах саналтай байна. Хэрлэн сум нь гадаадын иргэн,

харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгохтой холбоотой улсын тэмдэгтийн хураамжаас 2020 онд 774.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 726.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

- **Үйл ажиллагааны орлого** өмнөх оны гүйцэтгэлээс 118.1 сая төгрөг буюу 30.0 хувиар бууруулан төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 34.9 сая төгрөг буюу 12.6 хувиар тасарсан байна. Энэ нь цар тахалтай холбоотой орлого тодорхойлох боломжгүй иргэдийн орлого буурснаас шалтгаалсан байна.

2. Татварын бус орлогын талаар:

Нийт 7,498.8 сая төгрөгийн татварын бус орлогын 59.2 хувь буюу 4,439.8 сая төгрөгийг хандив, тусламжийн орлого эзэлж байна.

Тайлант онд татварын бус орлого нь 849.2 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар давж биелсэн байна.

Орлогуудыг нэр төрөл бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

- Хүүгийн орлого 35.9 сая төгрөг буюу 59.8 хувиар тасарсан нь “Ковид-19”-ийн цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор ЗГ-ын шийдвэрээр иргэдийн зээл, зээлийн хүүгийн төлөлтийг хойшлуулснаас шалтгаалсан байна.
- Торгуулийн орлого нь тодорхойлох боломжгүй орлого бөгөөд тайлант онд төлөвлөсөн хэмжээнээс 516.4 сая төгрөг буюу 43.6 хувиар давж биелсэн байна.
- Бусад татвар буюу нэр заагдаагүй татварын орлого нь урьдчилан тооцох боломжгүй орлого тул Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь заалтын дагуу төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 97.1 сая төгрөг буюу 8.2 хувиар давж биелсэн байна.
- Тусламжийн орлогыг тайлант онд уул уурхай эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 10 аж ахуйн нэгжээс нийт 4,150.1 сая төгрөгийн хандивыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд Петрожайна Дачин тамсаг ХХК нь Матад, Халхгол сумдад 289.7 сая төгрөгийн тусламж үзүүлснээс 6.9 хувиар давж биелсэн байна.
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 77.7 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 18.0 сая төгрөгөөр буюу 23.2 хувиар тасарсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас “Аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн төсөл”-д Сангийн яамны баталсан орлогын доод хязгаараас бууруулан төлөвлөсөн 140.0 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэх санал хүргүүлснийг тусган нэмж баталсан байна.

2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.

Сангийн яам нь аймгийн 2020 оны төсвийн суурь зарлагын хязгаарыг 17.0 тэрбум төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.


Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн суурь зарлагыг Сангийн яамны хянасан хязгаараас 1.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөж батлуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.8 дахь “жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг, 31.1.3 дахь “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлийн талаар ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудит болон төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлтэд жил бүр өгч байсан боловч дахин давтагдан гарсаар байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 20.0 хувиар буюу 13,495.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж, батлуулсан байна.

Дүрслэл 3:

/тэрбум төгрөг/



Тайлант онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлснээс 2020 оны зарлагын төлөвлөгөө өссөн байна.

1. Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын өсөлт нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалж байна.

1.1. Аймгийн ИТХ, аймаг, сумдын ЗДТГ, Санхүүгийн хяналт аудитын алба, Орон нутгийн өмчийн албаны батлагдсан орон тоо Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдсэн байна. Орон нутаг төсвөө хязгаарт багтаах тухай хуулийн заалтад нийцүүлэн боловсруулахгүй байгаатай холбоотой ч, Сангийн яам орон тоог бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцохгүй байгаа нь мөн нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Аймгийн ИТХ нь МУЗЗНДНТУТХ-ын 20.3-т “Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 14.2.1-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно.” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.
- Сангийн яам нь ЗДТГ-уудын орон тоог ЗГ-ын тогтоолд заасан орон тоогоор баталж, нийтлэг үйлчилгээний албан хаагчдыг оруулан тооцдоггүй байна.
- Санхүүгийн хяналт, аудитын албаны орон тоо нь Мэргэжлийн хяналтын газраас шилжин ирсэн улсын байцаагчид, Орон нутгийн өмчийн алба бүтцийн өөрчлөлтөөр нэгдэхээс өмнөх Орон нутгийн өмчийн албаны 3, Худалдан авах ажиллагааны албаны 6 орон тооноос бүрдсэн байсан. Тус байгууллагууд шинэчлэн байгуулагдсанаар зайлшгүй байх үйлчилгээний албан хаагчид нэмэгдсэнээр Санхүүгийн хяналт аудитын алба 11, Орон нутгийн өмчийн алба 11 орон тоотойгоор тус тус ажиллаж байна. Бид өмнөх оны аудитаар УАГ-т ЗГ-ын нэгтгэсэн тайланд тусгуулах санал хүргүүлсэн боловч Сангийн яам хэвээр баталсан байна.

1.2. Аймгийн ИТХ, Хэрлэн сумын ИТХ-ын төсөв нь намын суудлын мөнгөөр нэмэгдсэн байна.

- Орон нутгийн төсвөөс аймгийн ИТХ-д суудалтай намуудад 2020 онд 66.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын 2012 оны 2 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг үндэслэн олгосон байна. Мөн 2021 онд 70.0 сая төгрөгийг олгохоор батлуулан 1 дүгээр улирлын байдлаар 10.0 сая төгрөгийг олгоод байна. Уг тогтоолыг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18,19 дүгээр заалт, улс төрийн намуудын бүлгийн саналыг үндэслэн гаргасан байна. Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох ямар нэгэн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа талаар өмнөх оны тайлангаар хүргүүлсэн ч хэвээр баталж зарцуулсан байна.

1.3. ТЕЗ нь Сангийн яамны хянасан дүнд тусгагдаагүй сумдын орон нутгийн нөөц хөрөнгийн зардлыг нэмж батлуулсан байна.



- Хууль, тогтоомжийн дагуу сумдын төсвийн бүрэлдэхүүнд Засаг даргын нөөцийн сангийн хөрөнгө байх ёстой бөгөөд төсвийн төслийн саналд тусган СЯ-нд хүргүүлдэг ч хянахдаа хасаж ирүүлдэг байдал хэвээр байна.

Өмнөх онд хийсэн аудитаар Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог бодитой тооцох талаар Сангийн яаманд уламжлуулах саналыг УАГ-т хүргүүлж байсан.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 3.3 тэрбум төгрөгийн санал дүгнэлтийг хүргүүлсэн боловч доорх 2.2 тэрбум төгрөгийн саналыг төсөвт тусгалгүйгээр хэвээр батлуулсан байна. Үүнд:

- **Төсвийн суурь зардалтай холбоотой:** Төсвийн суурь зардлыг Төсвийн тухай хуулийн 31.1.3 дахь “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх” гэсэн заалтыг мөрдөн ажиллах санал хүргүүлсэн боловч төсвийн суурь зарлагыг Сангийн яамны баталсан хязгаараас 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж баталсан.
- **ОНХС-ын төлөвлөлттэй холбоотой:** “Алслагдсан багт багийн мэдээллийн төв байгуулах” 71.3 сая төгрөгийн арга хэмжээнд Төсвийн тухай хуулийн 29.2 дахь “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна”, 31.1.3 дахь “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх”, Сангийн Сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.7 дахь заалтуудыг зөрчин санхүүжүүлсэн байна.
- **Төсвийн зардлын хуваарилалттай холбоотой:** “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуульд заасан хувь хэмжээг үндэслэлгүй тооцож 514.3 сая төгрөгөөр бууруулан төлөвлөж баталсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 78,085.8 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс жилийн эцсийн байдлаар 92.0 хувь буюу 71,866.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт:1. Зардлын төлөвлөлтийг гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа /сая.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	61,767.2	57,676.1	4,091.1	93.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,935.5	13,628.9	1,306.7	91.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,382.8	561.8	821.0	40.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,085.5	71,866.8	6,218.8	92.0

Төсвийн зарлагыг 8 хувиар хэмнэсэн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна.

Үүнд:

- Урсгал зардлыг дутуу зарцуулсан нь тайлант онд цар тахлын нөлөөгөөр Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн илүү цагийн хөлс, үдийн цай хоолны зардал, төрийн байгууллагуудын дотоод томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардлын гүйлгээг СЯ-наас хязгаарласантай.
- Хөрөнгийн зардлын гүйцэтгэлд дутуу байгаа нь тэвчиж болох зардлыг СЯ-наас хязгаарласантай.
- Эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 59.4 хувьтай байгаа нь тайлант онд СХС-гийн зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс зээл олгоогүйтэй холбоотой.


Дүрслэл:4. Зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь ангилан харуулбал:



Нийт зардлын 80.0 хувийг урсгал зардалд, 19.0 хувийг хөрөнгийн зардалд, 1.0 хувийг эргэн төлөгдөх зээл олголтод зарцуулсан байна.

Төсвийн зарлага өмнөх оноос 7.3 сая төгрөг буюу 11.3 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: урсгал зардал 5.3 сая төгрөг буюу 10.0 хувь, хөрөнгийн зардал 2.6 сая төгрөг буюу 23.5 хувиар өссөн, эргэж төлөгдөх зээлийн зардал 0.6 сая төгрөг буюу 49.7 хувиар буурсан байна.

Дүрслэл:5. Зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгаа.



Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн болох хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу тайлагнасан байна. Үүнд:

- **Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл:** Орон нутгийн хөрөнгө оруулалтын 31 төсөл арга хэмжээнд нийт 1,277,559.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 99.6 хувь буюу 1,271,847.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 0.4 хувь буюу 5,712.2 мянган төгрөг нь худалдан авах ажиллагааны үр дүнгээс бий болсон хэмнэлт байна.
- **Аймгийн авто замын сангийн санхүүжилт, гүйцэтгэл:** Авто замын сангийн 10 төсөл арга хэмжээнд нийт 336,500.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 98.4 хувь буюу 331,099.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 0.2 хувь буюу 5,400.8 мянган төгрөг нь худалдан авах ажиллагааны үр дүнгээс бий болсон хэмнэлт байна.
- **Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл:** Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх 21 төсөл арга хэмжээнд нийт 514,313.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 98.4 хувь буюу 506,054.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс 1.6 хувь буюу 8,259.0 мянган төгрөг нь худалдан авах ажиллагааны үр дүнгээс бий болсон хэмнэлт байна.
- **Аймгийн ОНХС-гийн санхүүжилт, гүйцэтгэл:** Аймгийн ОНХС-гийн 117 төсөл арга хэмжээнд нийт 6,624,633.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 95.6 хувь буюу 6,331,747.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Зүүн цементэн гүүрний хяналтын цэгийн байрны засвар /Хэрлэн сум/ – 5,400.0 мянган төгрөгийн өртөгтэй ажил хийгдээгүй байна./ Үүнээс 4.4 хувь буюу 287,486.3 мянган



төгрөг нь мал эмнэлэг, баяр наадмын зардлыг гүйцэтгэлээр нь олгосон болон худалдан авах ажиллагааны үр дүнгээс бий болсон хэмнэлт байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

- Аймаг, сумдын сургууль цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний 107 арга хэмжээний зардал болох 17.8 тэрбум төгрөг,
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 139 төсөл, арга хэмжээний 4.0 тэрбум төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 250 төсөл, арга хэмжээний 12.7 тэрбум төгрөг,
- Авто замын сангийн 11 арга хэмжээний 330.5 сая төгрөг,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжих 17 төсөл арга хэмжээний 1.0 тэрбум төгрөг,
- Бусад хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжих 21 төсөл арга хэмжээний 1.9 тэрбум төгрөг,

Гэвч КОВИД-19 цар тахлын улмаас хүүхдийн хоол хүнсний 82 арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны 335 төсөл арга хэмжээ буюу нийт тендер шалгаруулалтын 61.4 хувийг цахим хэлбэрээр www.tender.gov.mn сайтаар зохион байгуулсан.

Орон нутгийн 2020 оны хөрөнгө оруулалтын тайланд гүйцэтгэлийн аудит хийгдэж дуусаагүй байгаа тул үр дүн дүгнэх боломжгүй байна.

Тайлант онд нийт 9,974.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 42.4 дэх “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна”, Сангийн Сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай” журмын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт:2. Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа

		/мянган төгрөг/
№	Байгууллагын нэрс	Дүн
1	Аймгийн нэмэлт санхүүжилт	5,577,029.7
2	Сумдын нэмэлт санхүүжилт	4,397,835.6
	Нийт дүн	9,974,864.8

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 9,974.9 сая төгрөгийн орлого дараах эх үүсвэрүүдээс орсон байна.

Дүрслэл:6. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг харуулбал:



Тайлант онд нэмэлт санхүүжилтээс 9,781.6 сая төгрөгийг зарцуулж, 193.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.



Нийт зарцуулалтын 90.5 хувь буюу 9,684.3 сая төгрөгийг урсгал зардалд, 9.8 хувь буюу 290.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан давхардсан тоогоор 9 иргэнээс 797.5 сая төгрөгийн мөнгөн, 10,848.0 мянган төгрөгийн мөнгөн бус, 90 аж ахуйн нэгж байгууллагуудаас 124,610.6 сая төгрөгийн мөнгөн, 122,812.6 мянган төгрөгийн мөнгөн бус, нийт 259,068.7 мянган төгрөгийн хандив тусламж өгсөн байна.

Хүснэгт:3. Хандивын орлогын судалгаа**/мянган төгрөгөөр/**

д/д	Үзүүлэлт	Мөнгөн хандив		Мөнгөн бус хандив		Нийт дүн	Хувь
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн		
1	Иргэн	4	797.5	7	10,848.0	11,645.5	4.5
2	Аж ахуйн нэгж, байгууллага	53	124,610.6	48	122,812.6	247,423.2	95.5
Нийт дүн		57	125,408.1	55	133,660.6	259,068.7	100.0

Ковид-19 цар тахлын хандив тусламжийн орлогын 66.7 хувь буюу 172,904.5 мянган төгрөгийг 2020 онд зарцуулсан байна.

Хүснэгт:4. Хандивын зарцуулалтын судалгаа.**/мянган төгрөгөөр/**

Д/д	Зардлын төрөл	Зардлын дүн		Нийт дүн
		Мөнгөөр	Бараа материал	
1	Даавуун амны хаалт	13,846.8		13,847
2	Нэг удаагийн амны хаалт	3,598.0	21,198	24,796
3	Гар ариутгагч	1,331.8	314	1,646
4	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	50,808.4	12,704	63,512
5	Ажлын хөлс, илүү цагийн мөнгө	420.0		420
6	Шагнал урамшуулал, томилолт	6,951.6		6,952
7	Тээвэр, шатахуун, талон	8,976.4	9,104	18,080
8	Хоол, хүнс	9,192.1	3,830	13,022
9	Хяналт шалгалт	7,885.0		7,885
10	Сургалт, Сурталчилгаа	3,216.0	-	3,216
11	Бичиг хэрэг, Шуудан холбоо	4,962.7		4,963
12	Сэлбэг хэрэгсэл	2,955.0	500	3,455
13	Эмнэлгийн хэрэгсэл		9,311	9,311
14	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,800	1,800
Нийт дүн		114,143.8	58,760.7	172,904.5

Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын 100070031402 тоот харилцах дансанд 11,264.3 мянган төгрөг, бараа материалын 74,899.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.3 хувьтай байна.

ТЕЗ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөн батлуулсан байна. Төсвийн

ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 24 төсөл арга хэмжээ батлагдсан байна. Үүнд:

- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 1 хөтөлбөрт хамаарах 3 арга хэмжээ,
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 14 арга хэмжээ,
- Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх 7 арга хэмжээ.

Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнд ИТХ-ын үйл ажиллагаа, бодлогын хороод болон ажлын хэсгийн үйл ажиллагаа, сумдын хурлын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлууд хамрагдаж байна. Үүнд:

- Аймгийн ИТХ нь 5 удаа хуралдан, 28 асуудал хэлэлцэж 35 тогтоол баталсан байна.
- Бодлогын хороод нь улиралд 1-ээс доошгүй хуралдан, ИТХ-д 2 удаа дүгнэлтээ танилцуулж хэлэлцүүлсэн байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнүүдэд дараах хөтөлбөр, арга хэмжээнүүд багтсан байна. Үүнд:

Орон нутгийн төсөвт байгууллагууд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ахмад настны хөгжил хамгаалал, нийгмийн халамж, мал эмнэлгийн үйлчилгээ хот тохижилт, авто замын сан, мал хамгаалах сан, орон нутгийн төсвийн болон хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээ байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээнүүдээс 710.1 сая төгрөгийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан

- Зүүн цементэн гүүрний хяналтын цэгийн байрны засвар /Хэрлэн сум/ – 5.4 сая төгрөг

Сумдын орон нутгийн хөгжлийн сан

- Баянтүмэн сумын Хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагаа өнгөрөөх талбайг тохижуулах - 4.5 сая төгрөг
- Сэргэлэн сумын “Гэрэлт гудамж байгуулах” - 25.8 сая төгрөг
- Цагаан-Овоо сумын “Багийн иргэдэд үйлчлэх төв” “Багийн иргэний танхим тохижилт”, “Ахмадын байрны хашаа” “Хоггүй цэвэр орчин” “Хашаажуулалтад” “Орон сууц хөтөлбөр”-ийн 6 төсөл арга хэмжээ – 127.9 сая төгрөг
- Чойбалсан сумын “Багийн төвд хүүхдийн тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж /Жишиг хороолол”, “Хөдөөгийн багуудад гүний худгийн цооног гаргах” 2 төсөл арга хэмжээ - 24.9 сая төгрөг
- Халхгол сумын “Ялалт багийн ТАХ-ийн 4 айлын орон сууц” “Худаг гаргах” “Цогт-сүмбэр багийн зам засвар” “Ялалт багийн гэрэлтүүлэг” “Сумын хэтийн төлөвлөгөө” 5 төсөл арга хэмжээ-138.0 сая төгрөг
- Булган сумын “Хашаажуулах, гудамж эгнээ цэгцлэх” “Гэрэлтүүлэг Жалан, Жавхлант баг”-2 төсөл арга хэмжээ- 28.0 сая төгрөг
- Матад сумын “Сумын төвийн гэрэлтүүлэг” “Иргэдийн сургалт мэдээллийн төв” “Баянхангай багийн төвийн халаалт” 3 төсөл арга хэмжээ -355.6 сая төгрөг.

Нийт хөтөлбөр, арга хэмжээний 7.7 хувь хэрэгжээгүй нь татварын бус орлого төлөвлөсөн хугацаандаа ороогүйгээс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дахь хэсэгт “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт “Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл

ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.” гэж заасны дагуу 2020 онд Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрт хамаарах орон нутгийн ТШЗ-ийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 84.9-95,0 хувьтай дүгнэсэн байна.

ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Дорнод аймгийн Засаг даргын баталсан 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01 тоот удирдамжийн хүрээнд Дорнод аймгийн 11 сумын Орон нутгийн ерөнхий орлого, Засаг даргын нөөц сан, Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны батлагдсан хөтөлбөр, арга хэмжээ, төсвийн орлого, зарлагын хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

ТЕЗ-ын 2019 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Үүнд:

Хүснэгт:5. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.


№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн хувь
1	Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах.	100%
2	Төсвийг хязгаарт багтаах Төсвийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах.	0%
3	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтын үр дүнг сайжруулах.	0%

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого тасарсан байна.
2. Аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.3 хувьтай байна.
4. Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж байгаа хяналт нь цаг хугацааны хувьд оновчтой бус байгаагаас үр дүнд нөлөөлж байна.
5. Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар илэрсэн нийт 2,330.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгч, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгуулах 2 саналыг хүргүүллээ.



Төсвийн тухай хуулийн 8.9.5 дахь заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд иргэдийн хяналт тавих нөхцөлийг хангах зорилгоор 2019 оны хөрөнгө оруулалтын бус арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн 9,0 сая төгрөгийн <http://report.dornod.gov.mn/> цахим системийн ажлын тухайд 2020 оны төсвийн төлөвлөлт гүйцэтгэлд хамааралгүй тул аудитын тайлангаас хасаж өгнө үү.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



010621231



САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгуулах саналтай байна. Үүнд

1. Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн орлогыг сумын төсвийн бүрэлдэхүүнд оруулан төлөвлөн зарцуулж байгааг Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцүүлэх талаар Сангийн яаманд уламжлах.
2. Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог бодитой тооцох талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд зөвлөж байна.

1. Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод хяналтыг үр дүнтэй, цаг хугацаанд зохион байгуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 341/01/А-0060305
ДОА-2021/01/-СТА-ТЕЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дорнод аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь "жилийн төсвийн хязгаарт багтаасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5 дахь "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсвөөт зардлыг хэтрүүлсэн", 4.2.1.10 дахь "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн яамнаас тогтоосон хязгаарыг баримтлан ажиллах, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч М.Бадамсүрэн, төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц.Амгаланзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ

011040983



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 06

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газарт болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандах-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ



ДОА-2021/01/-СТА-ТЕЗ

ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД

Дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 16 тоот тушаалын хавсралт

№	Байгууллагын нэр	Аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Аймгийн ТЕЗ	ДОА-2021/1/СТА-ТЕЗ	1.Төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө Сангийн яамнаас тогтоосон хязгаарт багтаах Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.	2,330.5
Нийт дүн				2,330.5

